

ДАВХАР АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2017.03.22

Компанийн эрх бүхий албан тушаалтан миний бие холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн хүрээнд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтны давхар ажил эрхлэлттэй холбоотой зөвшөөрөгдсөн болон хориглосон хэм хэмжээний талаарх мэдээллийг түүвэрлэн танилцуулж байна.

Та бүхэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, шаардлагатай мэдээллийг цаг тухай бүр бичгээр мэдэгдэж, ажил олгогчийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ажиллана уу.

Нэг. Компанийн нийт ажилтан

Хөдөлмөрийн тухай хуулийн зохицуулалтаас:

Хэд хэдэн ажил, үүргийг зэрэг гүйцэтгэх талаар хуулийн 26 дугаар зүйлд дараах байдлаар хуульчилсан. Үүнд.

26.1-д: “Ажилтан ажлын цагтаа багтаан өөрийн буюу бусад байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгэх, өөрийн байгууллагад өөр ажил хослон гүйцэтгэх болон ажил олгогч ажилтантай тохиролцсоноор эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх буюу түүний ажлын ачааллыг нэмэгдүүлэн ажиллуулж болно.” гэж;

26.2-т: “Энэ хуулийн 28 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд ажилтан хэд хэдэн ажил олгогчтой хөдөлмөрийн зэрэгцсэн гэрээ байгуулан ажиллаж болно.” гэж.

Ажилтан хэд хэдэн ажил олгогчид нэгэн зэрэг ажиллахыг хориглох талаар мөн хуулийн 28 дугаар зүйлд дараах байдлаар хуульчилсан. Үүнд:

28.1-д: “Хуулийн этгээдэд эд хөрөнгө захиран зарцуулах эрх мэдэл хэрэгжүүлэх ажил, албан тушаалд ажилладаг ажилтан адил төрлийн үйл ажиллагаа явуулдаг өмчийн бусад төрөл, хэлбэрийн өмчлөгчтэй эрхэлж байгаа ажил, албан тушаалтайгаа ижил, эсхүл удирдах, хяналт тавих шинжтэй ажил, албан тушаалд ажиллахаар зэрэгцсэн гэрээ буюу контракт байгуулахыг хориглоно.” гэж;

28.3-т: “Энэ зүйлийг зөрчсөнөөс ажил олгогчид учруулсан хохирлыг ажилтан энэ хуульд заасны дагуу арилгах үүрэгтэй.” гэж.

Хөдөлмөрийн дотоод журмын зохицуулалтаас:

Гүйцэтгэх захирлын 2015 оны А/23 дугаар тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журмын хавсралт дахь

Ажлын байрны тодорхойлолт”-ын “А.Танилцуулга” хэсгийн 8-д: “Дараах тохиолдолд Ажилтан Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн хэд хэдэн ажил олгогчид зэрэг ажиллаж болно.

Мэргэжлийн дагуу багшлах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил;

Ажил олгогчийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхгүй бөгөөд ажил олгогч бичгээр зөвшөөрөл өгсөн бол ашиг сонирхлын зөрчил үүсэхээргүй бусад ажил, үүрэг;

Татварын албанд ажил үйлчилгээ хувиараа эрхэлж байгаа гэж бүртгүүлсэн, жилийн орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 80 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс илүүгүй, эсхүл төмс хүнсний ногооны тариалан болон ойн аж ахуй, зөгий, загас, амьтан үржүүлэг, сургалт-аялал, сургалтын бусад үйл ажиллагаанаас орлого олдог хувийн аж ахуйг давхар эрхэлж болно (зарим албан тушаалд энэ заалтыг оруулах шаардлагатай).

Давхар ажил эрхлэлтийн талаар ажил олгогчид бичгээр мэдэгдсэн байна.” гэж,

Мөн Ажлын байрны тодорхойлолтын “Г.Хүчин зүйлс” хэсгийн 2-т: “Ажлын байрны тодорхойлолтод дурдсан, ажил олгогчийн зөвшөөрөлгүйгээр хийж байгаа давхар ажил эрхлэлтийг ажил олгогч хожим мэдэж, зөвшөөрөөгүй бөгөөд ажилтан давхар ажил эрхлэлтээ зогсоохоос татгалзсан бол ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөрийн гэрээг шууд цуцална.” гэж тус тус заасан.

Хоёр. ХАСХОМ мэдүүлдэг албан тушаалтан:

А. ХАСХОМ мэдүүлэх үүрэг бүхий нийт албан тушаалтан нь Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангаж ажиллана.

“Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 18 дугаар зүйлд “Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалт”-ын талаар хуульчилсан. Тодруулбал,

- “18.1. Албан тушаалтан энэ хуулиар зөвшөөрснөөс өөр ажил албан тушаал давхар эрхлэхийг хориглоно.
- 18.5. Энэ хуулийн 18.2-18.4-т¹ зааснаас бусад албан тушаалтан дараахь ажлыг давхар эрхэлж болно.
 - 18.5.1 Хууль тогтоомж, олон улсын гэрээгээр болон Засгийн газраас баталсан журмаар зөвшөөрсөн ажил;
 - 18.5.2. Багшлах, эрдэм шинжилгээний болон бүтээлч ажил;
 - 18.5.3. Ашиг сонирхлын зөрчил үүсэхээргүй бол өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагын бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр бусад алба, гэрээний ажил, үүрэг;
- 18.6. Татварын албанд ажил үйлчилгээ хувиараа эрхэлж байгаа гэж бүртгүүлсэн, жилийн орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 80 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс илүүгүй, эсхүл төмс хүнсний ногооны тариалан болон ойн аж ахуй, зөгий, загас, амьтан үржүүлэг, сургалт-аялал, сургалтын бусад үйл ажиллагаанаас орлого олдог бол албан тушаалтан үүнийгээ давхар эрхэлж болно.” гэж заасан байна.

¹ УИХ, ЗГ-ын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, мөрдөх албаны албан тушаалтан, зэвсэгт хүчний албан тушаалтан

Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д: “Албан тушаалтан нийтийн албанд орох үед хуулиар зөвшөөрөөгүй өөр ажил, үүрэг, гэрээ гүйцэтгэж, эрх эдэлж байгаа бол **энэ тухай дээд шатны албан тушаалтанд бичгээр танилцуулах үүрэгтэй.**” гэж,

19.2-т: “Энэ хуулийн 19.1-д заасан танилцуулга хүлээн авсан албан тушаалтан ажлын байрны шаардлагыг харгалзан 30 хоногийн дотор давхар эрхэлж болохгүй алба, ажил, үүргээс чөлөөлөгдөх, гэрээ болон эрхийг цуцлах эсэх тухай шийдвэр гаргаж холбогдох албан тушаалтанд бичгээр мэдэгдэнэ.” гэж;

20 дугаар зүйлийн 20.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол албан тушаалтан энэ хуулийн 18.6-д зааснаас бусад аж ахуйн үйл ажиллагаа гардан эрхлэх болон аж ахуйн нэгжийн удирдах бүтцэд ажиллахыг хориглоно.” гэж,

20.4-т: Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтан тухайн хуулийн этгээдэд нийлүүлэх төрийн болон орон нутгийн хэрэгцээний бараа, ажил, үйлчилгээ худалдан авах захиалгын нийлүүлэгчээс ашиг авахыг хориглоно.” гэж,

20.5-д: “Албан тушаалтан нийтийн албанаас чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд албан үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа төрийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, улсын болон орон нутгийн нөөцийн хуваарилалт, удирдах, хянах, хариуцлага хүлээлгэх зэрэг асуудлаар шийдвэр гаргаж байсан аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч, хамтрагч болох, тус аж ахуйн нэгжээс хөрөнгө шилжүүлж авахыг хориглоно.” гэж тус тус заасан.

Б. Гүйцэтгэх захирал нь дээр дурдсан хуулийн зохицуулалтаас гадна Компанийн тухай хууль, Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан “Хөлсөөр ажиллах гэрээ”-ний дараах зохицуулалтыг харгалзана. Үүнд:

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.5-д “Хууль болон компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл зөвшөөрсөн тохиолдолд гүйцэтгэх захирал, эсхүл гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч багийн гишүүн нь өөр компани, аж ахуйн нэгжийн удирдлагад давхар ажиллаж болно.” гэж;

Хөлсөөр ажиллах гэрээний 1 дүгээр зүйлийн 1.3-т: “Гүйцэтгэх захирал нь компанийн гүйцэтгэх удирдлагын ажил үүргийг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхгүй, бусад аж ахуй нэгж, байгууллагад гэрээгээр өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгэхгүй” гэж тус тус заасан байна.